



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг
бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын код: ДГА-2023/30-8/ШТА-НА

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2023 оны 06 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntuikhuur.u@audit.gov.mn

О.Нарангарав

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Д.Дэмбэрэлсүрэн

Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Б.Алтанзул

Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn

М.Дүүрэнжаргал

Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Агуулга.....	1
Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёог.....	3
Дүрслэлийн товъёог.....	3
Зургийн товъёог.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4-5
Ерөнхий мэдээлэл.....	6
БҮЛЭГ А. Байгаль орчны талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн бодлогод тусгаж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.....	7-15
A.1 Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.....	7
A.1.1 Байгалийн орчны талаар мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудын зарим цаглаварт хугацаа хоорондоо нийцэхгүй байна.....	7
A.1.2 Аймгийн бодлогын баримт бичгүүд нь Монгол улсын урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй уялдсан байна.....	7-11
A.1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан ан агуурын болон усны сав газрын менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.....	11-13
A.2 Аймгийн засаг дарга нь харьяа төсөв захирагчидтай байгуулсан гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр түүнтэй холбогдсон харилцааг тусгаж үнэлж, дүгнэсэн байна.....	14
A.2.1. “БОАЖ-ийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.”.....	14
A.2.2.Аймгийн Засаг дарга сумдын болон, холбогдох агентлагийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэсэн байна.....	14-15
БҮЛЭГ Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалт хууль, журмын дагуу бүрэн хэрэгжихгүй байна.....	16-26
B.1. Аймгийн ИТХ нь байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум бүрээр тогтоож, шийдвэр гаргаагүй байна.....	16
B.1.1 Аймгийн хэмжээний байгалийн баялгийн дээд хэмжээг менежментийн төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөсөн байна.....	16-17
B.1.2. Аймгийн ИТХ нь журамд заасан төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааны дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум бүрээр тогтоож, шийдвэр гаргаагүй байна.....	17-19
B.1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.....	19-21
B.1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан тодорхойгүйгээс орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна.....	21-22
B.2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын төлөвлөлтийг менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ бүрээр төлөвлөсөн ч, байгаль орчны чиглэлийн бусад арга хэмжээнд санхүүжилтийг зарцуулсан байна.....	23
B.2.1. Төлбөрийн орлогын хэсгийг хуульд заасан хувь хэмжээг үндэслэн тооцож төлөвлөсөн байна.....	23-25
B.2.2. Төлбөрийн орлогын хэсгийг журамд зааснаас бусад байгаль орчинтой холбоотой арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулсан байна.....	25-26
БҮЛЭГ В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналтын үр дүнг үнэлээгүй байна.....	27-31
V.1. Мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, холбогдох төрийн байгууллагын уялдаа холбоог нягтаршуулах шаардлагатай байна.....	27
V.1.1 Мэдээллийн санг бүрэн бүрдүүлээгүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна.....	27-28
V.1.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог нягтаршуулах шаардлагатай байна.....	28-29
V.2. Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээгээр ирүүлсэн зөвлөмж, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	29
V.2.1. Хуулийн хэрэгжилтэд холбогдох байгууллагаас хяналт хийгдсэн хэдий ч бодит тоо мэдээлэлд үндэслээгүй байна.....	29-30
V.2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....	30-31
Аудитын дүгнэлт.....	32
Аудитын зөвлөмж.....	33
Аудитын санал.....	34
Холбогдох байгууллагын санал.....	35-39
Холбогдох байгууллагын саналд өгсөн санал.....	40
Аудитын тайлан баталгаажуулсан тушаал.....	41

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БХНС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх
ГӨДСГ	Галба Өөш долоодын говийн сав газрын захиргаа
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
МУ	Монгол улс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УГГХДТСГ	Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газар
УИХ	Улсын их хурал

Хүснэгтийн товъёог:

Утга	Тайлбар
Хүснэгт № 1	Аймгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын мэдээ
Хүснэгт № 2	Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2022 оны Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ
Хүснэгт № 3	Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд батлагдсан менежментийн төлөвлөгөө
Хүснэгт № 4	Ан агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө
Хүснэгт № 5	Аймгийн Засаг дарга БОАЖЯ-ны сайдтай 2021-2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд өгсөн үнэлгээ
Хүснэгт № 6	Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа
Хүснэгт № 7	Төлбөрийн орлогын хэсгийн тооцоолол
Хүснэгт № 8	Аймгийн тусгай зориулалтаар агнуулах агнуурын тоо хэмжээ
Хүснэгт № 9	Дорноговь аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хуульд заасан хувь хэмжээг тооцсон дүн
Хүснэгт № 10	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсөв
Хүснэгт № 11	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос арга хэмжээнд зарцуулсан төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт № 12	Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс бусад үйл ажиллагаанд зарцуулсан байдал
Хүснэгт № 13	БОАЖЯ-аас болон аудитаар илэрсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ (2021-2022 онуудад)
Хүснэгт №14	Аймгийн ИТХ-аас 2021-2023 онд батлагдсан газрыг улсын болон аймгийн тусгай хамгаалалтад авах шийдвэрийн мэдээлэл
Хүснэгт №15	Байгаль орчны мэдээллийн санд мэдээлэл оруулсан байдал
Хүснэгт №16	БОАЖЯ-аас болон аудитаар илэрсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ (2021-2022 онуудад)
Хүснэгт №17	Аймгийн ИТХ-аас 2021-2023 онд батлагдсан газрыг улсын болон аймгийн тусгай хамгаалалтад авах шийдвэрийн мэдээлэл

Дүрслэлийн товъёог:

Утга	Тайлбар
График № 1	Төлбөрийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт
График №2	Ус ашиглах зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал
График №3	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл, харьцаа

Зургийн товъёог:

Утга	Тайлбар
Зураг № 1	Аймгийн агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө
Зураг № 2	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээний доод хязгаар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: 1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх; 3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх;
Аудитын хамрах хүрээ	Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Татварын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргаа, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа зэрэг байгууллагуудын 2021, 2022 оны үйл ажиллагааг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: - Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль; - Хууль тогтоомжийн тухай хууль; - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; - Татварын ерөнхий хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Ойн тухай хууль

	- Усны тухай хууль - Амьтны тухай хууль - Газрын тухай хууль - Байгалийн ургамлын тухай хууль - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль - Төсвийн тухай хууль; - 2021 оны төсвийн тухай хууль; - 2022 оны төсвийн тухай хууль; - 2023 оны төсвийн тухай хууль; - Шилэн дансны тухай хууль; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай; - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол/ - “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/ - Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам" - Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам" - Холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актууд
Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор О.Нарангарав, аудитор Д.Дэмбэрэлсүрэн, Б.Алтанзул, М.Дүүрэнжаргал нар гүйцэтгэв. Аудитын дэд хөтөлбөр, төлөвлөгөөг 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдөр батлуулж, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 05 дугаар сарын 11-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж, тайланг 2023 оны 06 дугаар сарын 16-ны дотор боловсруулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл:

Дорноговь аймгийн газар нутгийн нийт талбайн хэмжээ 10,947.2 мянган га бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар хөдөө аж ахуйн газар 9,490.5 мянган га буюу 86.7%, хот, тосгон бусад суурины газар 211.5 мянган га буюу 1.9%, зам, шугам сүлжээний газар 63.0 мянган га буюу 0.6%, ойн сан бүхий газар 158.5 мянган га буюу 1.4 хувь, усны сан бүхий газар 27.8 мянган га буюу 0.2 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 995.9 мянган га буюу 9.1 хувийг тус тус эзэлж байна.

Аймагт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд усны сав газрын менежментийн төлөвлөгөө, ан агнуурын менежментийн төлөвлөгөө, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө батлагдсан байна.

2022 оны байдлаар аймгийн хэмжээнд ан агнуурын 6 бүс нутагт 4 төсөл хэрэгжүүлэгчийн менежментийн төлөвлөгөөг батлан, 195.5 мянган м3/жил усыг ашиглуулахаар 30 дүгнэлтийг олгосон байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос аймгийн хэмжээнд ан агнуурын төлбөр, усны нөөц ашигласны төлбөр, газрын нөөцийг ашигласны төлбөрийн орлогууд төвлөрдөг бөгөөд 2021 онд нийт 1,824.0 сая төгрөгийн 2022 онд нийт 8,758.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Аймгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын мэдээ

Хүснэгт №1

		<i>/сая төгрөг/</i>	
№	Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	2021	2022
1	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	216.4	644.7
2	Газрын нөөцийн төлбөрийн орлого	1,060.0	7,412.6
3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	547.6	700.7
	Нийт	1,824.0	8,758.0

Аймгийн Засаг дарга Байгаль орчин, аялал жуулчлалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 16.2 хэсгийг үндэслэн БОАЖЯ-ны сайдтай хамтран ажиллах гэрээг жил бүр байгуулж байна. Энэ гэрээнд орон нутгийн төсвөөс 2021 онд 460.5 сая, 2022 онд 968.5 сая, 2023 онд 1,292.0 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулахаар тусгасан байна.

Аймгийн ИТХ-аар баталсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын төсвийн задаргааг аймгийн Засаг даргын захирамжаар тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр баталдаг байна. Тус зардалд 2021 онд 450.6 сая, 2022 онд 919.7 сая төгрөгийг тус тус зарцуулснаас Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу 2021 онд 349.5 сая, 2022 онд 754.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2022 онд 14 сумдад байгаль орчныг хамгаалах 3 чиглэл¹-ээр хяналт шалгалтыг хийсэн байна.

¹ 1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн биелэлттэй танилцах

2.Усны тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн хэрэгжилттэй танилцах

3.Газрын тухай хууль тогтоомжийн биелэлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах, ИТХ-аас батлан гаргасан тогтоол шийдвэрийн биелэлттэй танилцах

**БҮЛЭГ А. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛИЙГ
ОРОН НУТГИЙН БОДЛОГОД ТУСГАЖ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАСАН
БАЙНА.**

А.1. Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн байна.

А.1.1. Байгалийн орчны талаар мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудын зарим цаглаварт хугацаа хоорондоо нийцэхгүй байна

Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1-д аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага *"батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх"* гэж заасан.

Гэтэл Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.4-д *"агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж"*, 8 дугаар зүйлийн 8.4.1-д *"төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх"*, МУЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан *"Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам-ын 2.5-д "Сум, дүүргийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ"* гэсэн заасан нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтын цаглаварт хугацаатай зөрчилдөж байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан *"Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар хэсгийн 3.8-т "Сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 3.6-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-2-А маягтын дагуу боловсруулж, жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ"*, 3.9-т *"Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-А маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна"* гэсэн заалтуудад цаглаварт хугацаанд давхцал гарч, БОАЖГ нь сумдын ирүүлсэн саналыг хянаж, дүгнэн нэгтгэх хугацаагүй байна.

Иймд дээрх хууль, журмуудын нийцлийг хангаж өөрчлөлт оруулах нь шаардлагатай байна.

А.1.2. Аймгийн бодлогын баримт бичгүүд нь Монгол улсын урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй уялдсан байна

Монгол Улсын байгаль орчны салбарын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна гэсэн үндсэн зарчмыг баримтлан, байгаль орчны талаар “Ногоон хөгжил” бодлогын хүрээнд МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д 4 зорилтын 41 үйл ажиллагааг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-д 4 зорилтын 18 үйл ажиллагааг, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны

хөтөлбөр”-т 9 зорилтын 12 үйл ажиллагааг, “МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-д 20 үйл ажиллагааг, “МУ-ын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-д нийт 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тус тус тусгагдсан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 “ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх эрхтэй”, 60 дугаар зүйлийн 60.1.1 “Аймгийн Засаг дарга нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах эрхтэй”, 60.1.3 “..... аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөгөө, хөтөлбөрийн төсөл боловсруулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх эрхтэй” гэж заасны дагуу Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан ногоон хөгжлийн талаарх бодлогыг орон нутгийн баримт бичгүүдэд дараах байдлаар тусгаж баталсан байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/05 дугаар тогтоолоор баталсан “Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн 6-т заасан “Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилго”-ын хүрээнд нийт 3 зорилтын 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс байгалийн нөөцтэй холбоотой:

- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн экосистем бүхий газар нутгийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах,
- Усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/63 дугаар тогтоолоор баталсан “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024”-т 5.1-т заасан “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилт”-ын хүрээнд 9 зорилтын 21 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс байгалийн нөөцтэй холбоотой:

- Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулах,
- Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх,
- “Ногоон Дорноговь” арга хэмжээг хэрэгжүүлж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх,
- Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх,
- Аймгийн Тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг ажлыг тусгасан байна.

Аймгийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн Ногоон хөгжил бодлогод тусгагдсан үйл ажиллагааг үндэслэн аймгийн 2021 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 21, 2022 оны төлөвлөгөөнд 9 зорилтын 16, 2023 оны төлөвлөгөөнд 9 зорилтын 27 үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталсан бөгөөд байгалийн нөөцтэй холбоотой:

- усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар нэгдсэн менежментийг сайжруулах, ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх, "Ногоон Дорноговь" арга хэмжээг хэрэгжүүлж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх,

Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх ажлуудыг тусгасан байна.

Үндэсний урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг орон нутгийн бодлогын баримт бичигт тусгаж баталсан байх ба Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 9, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-т 8, аймгийн 2021, 2022, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус тусгажээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5²-д ИТХ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр заасан.

Аймгийн **хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг холбогдох журамд заасан хугацаанд гаргаж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлжээ.**

Аудитын хамрагдсан хугацаанд Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-ийн хэрэгжилт, аймгийн 2021, 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг баримт бичиг тус бүрээр үнэлж дүгнэсэн байна.

**Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2022 оны
Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ**

Хүснэгт №2

№	Хөгжлийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичиг	Үнэлгээ, дүгнэлт
1	Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт	2022 оны 11 дүгээр сарын 18-ны 02/05 дугаар тогтоолоор 91 хувь “Үр дүнтэй”
2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-ийн хэрэгжилт	2022 оны 11 дүгээр сарын 20-ны 02/06 дугаар тогтоолоор 92.9 хувь “Үр дүнтэй”
3	Аймгийн 2021 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт	2021 оны 12 дугаар сарын 02-ны 05/02 дугаар тогтоолоор 94.3 хувь “Тодорхой үр дүнд хүрсэн”
4	Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт	2022 оны 11 дүгээр сарын 20-ны 05/02 дугаар тогтоолоор 96.3 хувь “Тодорхой үр дүнд хүрсэн”

Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтээс байгалийн нөөцтэй холбоотойг авч үзвэл:

- Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд үе шаттайгаар хийж, ашиглалтын зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд 50.0 сая төгрөгийг төлөвлөж, 44.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Амьтны тархац, нөөцийн судалгаа хийж, “Борхойн Баян Бүрд” ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн талбайн хүлэмжид говийн ховор ургамлууд болох хармаг, сухай, жигд зэрэг 3 төрлийн ургамлыг 320 м² талбайд үрээр болон мөчрөөр үрслүүлж, ховор бутлаг ургамал болох хайлаас модны 3 кг, загийн 1 кг үр, сухай модны 500 ширхэг мөчир бэлтгэж үр, суулгацын нөөцийг бүрдүүлж, Өргөн сумын цэцэрлэгт хүрээлэнд хармагны модыг тарьж нутагшуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн байна.
- Усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулах зорилтын хүрээнд 2 суманд 6 худаг, уст цэгт эрүүл ахуйн бүс тогтоож, хашаажуулан, тэмдэгжүүлсэн. Хүн амыг стандартын

² Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх

шаардлага хангасан ундны усаар хангаж ажлын хүрээнд 3,681.1 сая төгрөгийн санхүүжилтээр 6 сумын ундны усны худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж, хашаажуулах камержуулах ажлыг зохион байгуулсан, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг шинэчлэн тогтоож, ус түгээх байрыг цахимжуулж иргэдийг 24 цагийн турш тасралтгүй усаар хангагдах боломжийг бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-ийн хэрэгжилтээс:

- Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, нүүдлийн замыг чөлөөлөхөд орон нутгийн төсөв, ОНХС-ийн санхүүжилт, бусад хандив тусламжийн нийт 42.3 сая төгрөгийн санхүүжилтээр ус нөөцлөх хөв суурилуулан, цөөрөм сэргээж, худагт сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж суурилуулан бэлчээрийн усан хангамжийн нэмэгдүүлснээр зэрлэг амьтдыг ундаалах боломжийг тус тус бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. Мөн 4 сумдад 544 боодол өвсийг бэлтгэж, зэрлэг амьтдын тархац газруудад байршуулан био техникийн арга хэмжээг хэрэгжүүлж 10 удаагийн эргүүлийн ажлыг хийж өргөс тор авах, нүхэн гарцыг чөлөөлөх ажлуудыг гүйцэтгэсэн.
- Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, ойр орчмын 88,5 га талбайг цэвэрлэж, 178,7 тн хог хаягдлыг 29 тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн байна. 8 сумдын 40 худагт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулан, Сайншанд, Замын -Үүд сумдын нийт 19 цэцэрлэг, 8 сургууль, “Чандмань -Илч” ХХК, “Чандмань бадрал” ХХК -ийн ундны усны чанар, аюулгүй байдал, түгээлтэд хяналт шалгалт хийж, хэрэглээний уснаас 54 сорьц авч, шинжилгээнд хамруулан, заавар зөвлөмж өгсөн. Орон нутгийн төсвийн 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Дэлгэрэх сумыг инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбон усан хангамжид зориулан шинээр 3 худаг гарган эх үүсвэрийг хамгаалан хашаажуулах зэрэг ажлыг хийж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн 2021 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтээс:

- Сум бүр хүн амын усан хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэхэд анхаарч 40 худаг, 19 цэцэрлэг, 8 сургууль, ус хангамжийн ОНӨХХК-ны ундны усны чанар, аюулгүй байдал, түгээлтэд хяналт шалгалт хийж, хэрэглээний уснаас 54 сорьц дээж авч шинжилгээнд хамруулан, заавар зөвлөмж өгсөн байна.
- Даланжаргалан, Иххэт, Өргөн, Сайншанд сумдад 430 боодол өвсийг бэлтгэж, зэрлэг амьтдын тархац газруудад байршуулан био техникийн арга хэмжээг хэрэгжүүлж 10 удаагийн эргүүлийн ажлыг хийж өргөс тор авах, нүхэн гарцыг чөлөөлөх ажлуудыг хийсэн байна.
- Хавар, намрын мод тарих аянаар аймгийн хэмжээнд 1933 өрх 9 төрлийн 11544 ширхэг мод, 151 ААНБ 22.1 га талбайд 14 төрлийн 26200 ширхэг мод, нийтийн эзэмшлийн 16.9 га талбайд 7 төрлийн 42846 ширхэг модыг суулгаж нийт 45.5 га талбайд 91186 ширхэг мод тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад шинээр суулгасан модны тоо 3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтээс:

- Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан 10 төрлийн томоохон сургалт, арга хэмжээнд орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлнэ. Хамрагдах хүний тоо 17000 давхардсан тоогоор 18248 иргэн, 90 гаруй цэцэрлэгийн багш хамруулсан.
- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 32.9 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдгээс Алтанширээ сумын “Хайлсан шанд”, “Холбоогийн уул”, “Баян буурал”, Эрдэнэ сумын “Цант хайрхан”, “Хар дэлийн шүү”, Хөвсгөл сумын “Уушны говийн өргөтгөл” зэрэг 52,290.3 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Улаанбадрах, Мандах, Иххэт, Сайншанд, Даланжаргалан

сумдын улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 24 байршил газрыг 22.8 сая төгрөгийн санхүүжилтээр тэмдэгжүүлсэн.

Орон нутгийн бодлогын баримт бичигт тусгагдсан "Ногоон хөгжил" бодлогын хүрээнд ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд үе шаттайгаар хийж, ашиглалтын зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулж, аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэн, “Ногоон Дорноговь” арга хэмжээний хүрээнд ногоон байгууламжийн хэмжээг нэвтрүүлэх ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

А.1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан ан агнуурын болон усны сав газрын менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ойн, усны нөөц, ан агнуур, тусгай хамгаалалттай газар нутаг зэргийн менежментийн төлөвлөгөөг байгалийн баялгийн нөөцийн үнэлгээнд үндэслэж төлөвлөсөн байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд батлагдсан менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №3

№	Менежментийн төлөвлөгөө	Баталсан шийдвэрийн огноо, дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч	Хяналт тавих
1	Усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	БОАЖС-ын 2019.05.31-нй А/233 тушаал	2019-2030	ГӨДГСГЗ, УГХДТСГЗ	БОАЖЯ, Аймгийн Засаг дарга
2	Агнуурын нөөц бүхий аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө	АИТХ-ийн тэргүүлэгчдийн 2019 оны №03 хурлаар дэмжсэн. БОАЖЯ-аар 2019 онд батлуулсан.	2019-2024	Аймгийн БОАЖГ, ТББ, нөхөрлөлүүд	Аймгийн Засаг дарга
3	Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө	Байхгүй	-	-	-
4	Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөө	АИТХ-ын 2018.05.07 №08/01	2018-2022	Аймгийн БОАЖГ	Аймгийн Засаг дарга

Ан агнуурын менежментийн төлөвлөгөө: Дорноговь аймагт 53 зүйлийн хөхтөн амьтан байршин амьдардаг нь Монгол орны нийт хөхтний 38.4% болно. Тус аймагт бүртгэгдсэн хөхтний 6 зүйл тутмын 1 нь Засгийн газрын тогтоолоор “ховор” гэж үнэлэгдсэн, 6 зүйл тутмын 1 нь Монгол улсын “Улаан ном”-нд тэмдэглэгдсэн, 9 зүйл тутмын 1 нь Ховор амьтан ургамлын зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) жагсаалтад, 13 зүйл тутмын 1 нь Нүүдлийн зүйлүүдийн тухай конвенцийн (CMS) жагсаалтад тус тус бүртгэгдсэн байна. Тус аймгийн хөхтний нийт зүйлүүдийн 28.3% нь ховордлын зэрэгт бүртгэгдсэн байна.

Амьтны тухай хуулийн 4.1.11-т "Ан агнуурын менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг хэлнэ, 5.3.2-т “Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

нь агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 5.8.3-т “аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага нь энэ хуулийн 5.3.2-т заасан ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”, 21.4.1-т “Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага агнуурын нөөцийг хамгаалах талаар агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захиалга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байна.

Аймгийн 2019-2023 онд хэрэгжих ан агнуурын нэгдсэн менежментийн төлөвлөгөөг АИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны №03 дугаар хурлаас төслийн саналыг дэмжин, төлөвлөгөөг БОАЖЯ-аар батлуулсан байна.

Аймгийн хэмжээнд ан агнуурын 6 бүс нутагтай бөгөөд 2019-2025 онд хэрэгжих 4 бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгчид аймгийн ан агнуурын нэгдсэн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулан аймгийн БОАЖГ-аар хянуулан, БОАЖЯ-аар батлуулж, төлөвлөгөөний дагуу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Агнуурын бүс нутгийн 2 төсөл хэрэгжүүлэгчийн менежментийн төлөвлөгөө 2022 оны 9 сард аймгийн БОАЖГ-аар хянагдаж, БОАЖЯ-аар батлуулахаар хүргэгдсэн байна.

Ан агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

№	Менежментийн төлөвлөгөө	Баталсан шийдвэрийн огноо, дугаар	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөл Хэрэгжүүлэгч	Төсөв
1	Эрдэнэ сумын "Хангинуур" агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө	Сумын ИТХ-ын 2017 оны 40-р тогтоол, сумын ЗД-тай хамтран ажиллах 2017 оны №2 тоот гэрээ. БОАЖГ-ын даргаар батлуулсан	2019-2023	"Маунтэйн Хантинг" ХХК, "Мөнийн ус-Эрдэнэ ИН"	70.0
2	Мандах сумын "Таван баян" агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө	Сумын ИТХ-ын 2018 оны 12-р тогтоол, сумын ЗД-тай хамтран ажиллах 2018 оны №01/18 тоот гэрээ. БОАЖГ-ын даргаар батлуулсан	2019-2023	"Маунтэйн Хантинг" ХХК, "Баянтал Оюут ИН"	70.0
3	Хатанбулаг сумын "Хатны булаг" агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө	БОАЖЯ-аар батлуулсан	2021-2025	"Хутаг уулын хөндий" нөхөрлөл	15.5
4	Хатанбулаг сумын "Хутаг уул" агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө	БОАЖЯ-аар батлуулсан	2021-2025	"Монгол сафари" ХХК	22.0

Төсөл хэрэгжүүлэгчид менежментийн төлөвлөгөөний тухайн онд хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн БОАЖГ-т ирүүлсэн байна.

Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний 4.1.4-т “аймгийн БОАЖГ нь жил бүр агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, ААН ба нөхөрлөлүүдийн хамтын ажиллагааны үр дүнг үнэлэх...” гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр байтал уг заасан ажлыг хийгээгүй орхигдуулсан байна.

Усны сав газрын менежментийн төлөвлөгөө: Усны тухай хуулийн 4.7.-т “Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг энэ хуулийн 4.4-т заасан ашиглах боломжит нөөцийн хэмжээг үндэслэн боловсруулна”, 17.1.1-т “Сав газрын захиргаа нь сав газрын менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулна”, 17.1.2-т “Сав газрын захиргаа нь сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн болон салбар дундын

зохицуулалтыг хангах, хэрэгжилтэд хяналт тавина” гэж тус тус заасны дагуу усны сав газрын менежментийн төлөвлөгөөг 2019-2020 он буюу 1, 2021-2025 он буюу 2, 2026-2030 он буюу 3 гэсэн үе шаттай хэрэгжихээр үйл ажиллагааг төлөвлөн боловсруулж, БОАЖС-ын 2019 оны А/233 дугаар тушаалаар батлуулсан байна.

Аймгийн усны сав газрын бүс нутаг нь Галба-Өөш долоодын говийн болон Умард говийн Гүвээт-Халхын дундад талын гэсэн 2 сав газрын захиргаанд хамрагддаг байна.

Усны сав газрын менежментийн төлөвлөгөөний дагуу сав газрын захиргаанууд жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Гүйцэтгэлийн хэрэгжилт 2021 онд 80.1% буюу сайн, 2022 онд 92.1% буюу маш сайн гэж тус тус үнэлэгдсэн байна.

Ойн менежментийн төлөвлөгөө: Аймгийн ойн сангийн нийт талбай 2022 оны байдлаар 116893 га бөгөөд 55843 га талбай нь ойгоор бүрхэгдсэн, 61050 га талбай нь ойгоор бүрхэгдээгүй талбай байна. Ойн сангийн 54.7 мянган га нь байгалийн ой, 1.1 мянган га нь сөөг торлог, 51.5 мянган га нь тармаг, 9.6 мянган га нь заган ой байна. *Мэдээний эх сурвалж: <https://www.eic.mn/>*

Ойн тухай хуулийн 3.1.6-т “ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг хэлнэ, 17.2.10-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэж заасан боловч аймгийн ойн менежментийн төлөвлөгөө батлагдаагүй байна.

Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөө: Орон нутгийн тусгай хамгаалалттай 216 газрын 4,867.8 мянган га талбай бүртгэлтэй бөгөөд энэ нь аймгийн нийт газар нутгийн 44.5%-ийг эзэлж байна. *Мэдээний эх сурвалж: <https://www.eic.mn/>*

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 2¹.1-т “тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө” гэж тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд болон ойрын хугацааны төлөвлөгөө бүхий баримт бичгийг хэлнэ, 6¹5-т “Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг менежментийн төлөвлөгөөтэй байж болох бөгөөд төлөвлөгөөг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”, 28.4-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг орон нутгийн төсөвт тусгана” гэж заасан байна.

Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 2018-2022 оны менежментийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2018 оны 08/01 дүгээр тогтоолоор батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлан мэдээг хүргүүлэн ажилласан байна.

А.2 Аймгийн засаг дарга нь харьяа төсөв захирагчидтай байгуулсан гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр түүнтэй холбогдсон харилцааг тусгаж үнэлж, дүгнэсэн байна

А.2.1. “БОАЖ-ийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10-т “Нэгжийн удирдлагаар байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлтийн ажлыг төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлнэ, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Энэ хуулийн 14.1.6, 14.1.11-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж болно”, 39.4-т “Энэ хуулийн 39.1-д заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, дотоод аудит хийнэ” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга БОАЖЯ-ны сайдтай 2021, 2022, 2023 онуудад байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах №21-08, №22-08, №23-08 дугаар бүхий гэрээг байгуулан ажилласан байна.

Сайдтай байгуулсан гэрээнд 2021 онд нийт 9 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг 380.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээнд 185.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 31 арга хэмжээнд 150.9 сая төгрөгийг зарцуулж, нэмэлтээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2 арга хэмжээг 38.5 сая төгрөгөөр хэрэгжүүлж гэрээг 81.9 хувьтай дүгнүүлсэн байна.

Харин 2022 онд нийт 7 зорилт 40 арга хэмжээг 817.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээнд тусгаснаас, байгалийн нөөц ашигласны төлбөр түүнтэй холбогдох 5 зорилтын хүрээнд 19 арга хэмжээнд 529.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 19 арга хэмжээнд 520.6 сая төгрөгийг зарцуулж, гэрээний хэрэгжилт 88.9 хувиар дүгнэгдсэн байна.

Аймгийн Засаг дарга БОАЖЯ-ны сайдтай 2021-2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд өгсөн үнэлгээ

Хүснэгт №5

№	БОАЖЯ-ны сайдтай байгуулсан гэрээ	Үнэлгээ, дүгнэлт
1	№21-08 дугаартай хамтран ажиллах гэрээ	2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ажлын хэсгийн үнэлгээгээр 81.9 хувь “В буюу сайн”
2	№22-08 дугаартай хамтран ажиллах гэрээ	2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ажлын хэсгийн үнэлгээгээр 88.9 хувь “В буюу сайн”

Мөн 2023 онд 6 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг 2,000.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас байгалийн нөөц ашигласны төлбөр түүнтэй холбогдох 4 зорилтын хүрээнд 15 ажлыг 712.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

А.2.2. Аймгийн Засаг дарга сумдын болон, холбогдох агентлагийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10-т “Нэгжийн удирдлагаар байгаль орчныг хамгаалах,

орчны бохирдол, нөхөн сэргээлтийн ажлыг төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлнэ, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна”, 40.3-д “Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга нь 2021, 2022, 2023 онд 14 сумын Засаг дарга, БОАЖГ-ын даргатай хамтран ажиллах гэрээг байгуулж, 2021, 2022 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажилласан байна.

Сумдын засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг авч үзэхэд 2021 онд 7 зорилтын хүрээнд 315 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 254 арга хэмжээг хэрэгжүүлэн, дундаж үнэлгээ 83.7 хувьтай, 2022 онд 5 зорилтын хүрээнд 182 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлийг сум тус бүрээр үнэлж дундаж үнэлгээ 69.5 хувьтай дүгнэгдэж, өмнөх оноос 14.2 хувиар хэрэгжилт буурсан байна.

Аймгийн засаг дарга Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргатай хамтран ажиллах гэрээг байгуулахдаа БОАЖС-тай байгуулсан гэрээ, аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, аймгийн байгаль орчны чиглэлээр батлагдсан менежментийн төлөвлөгөө зэрэгт тусгагдсан үйл ажиллагаанаас 2021 онд байгаль орчин нөхөн сэргээх үйл ажиллагааны чиглэлээр нийт 6 зорилтын 24 үйл ажиллагаанаас байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааны хүрээнд 3 зорилт 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийн биелэлтийг 87.3 хувиар, 2022 онд 6 зорилт 37 арга хэмжээнээс 3 зорилт 10 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж, гэрээний хэрэгжилтийг 85.1 хувиар дүгнэсэн байна.

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА.

Б.1. Аймгийн ИТХ нь байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум бүрээр тогтоож, шийдвэр гаргаагүй байна


Б.1.1. Аймгийн хэмжээний байгалийн баялгийн дээд хэмжээг менежментийн төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөсөн байна

Байгал орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1.2-т “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтооно”, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 2.2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 2.4-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 2.3-т заасныг үндэслэн ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум, дүүрэг тус бүрээр тогтооно” гэж заасан байна.

Аймгийн 2019-2023 онд хэрэгжих ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Аргаль, агнуур судлалын төв” ТБ мэргэжлийн байгууллага гүйцэтгүүлэн ан агнуурын нөөцийг тодорхойлсон байна. Тус ан агнуурын менежментийн төлөвлөгөөг үндэслэн аймгийн хэмжээний 6 агнуурын бүс нутагт төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд нэгжийн менежментийн төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна.

Аймгийн агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөө

Зураг №1



Аймгийн Засаг дарга ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоол, ан агнуурын менежментийн төлөвлөгөө, холбогдох хууль тогтоомжийн дагуу тухайн жилд ашиглах ан агнуурын нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг БОАЖГ-аараа дамжуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн ажилласан байна. Журам хэрэгжиж эхэлснээр 2022 онд ан агнуурын 6 бүс нутгаас 8 угалзыг тусгай зориулалтаар агнуулах саналыг хүргүүлжээ.

Аймгийн ан агнуурын бүс нутгаас 2021 онд агнах угалзын тоо хэмжээг БОАЖС-ын 2020 оны А/701 тоот тушаалаар 5 агнуурын бүс нутагт 8 угалзыг, 2022 оны тоо хэмжээг БОАЖС-ын 2022 оны А/208 тоот тушаалаар аймгийн 4 агнуурын бүс нутагт 10 угалзыг тусгай зориулалтаар агнах хуваарийг баталсан байна.

Усны газраас газрын доорх усны нөөцийг усны орд болгоноор гаргадаг боловч Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт “Монгол улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил болон ус хангамжийн эх үүсвэр зэрэг нь маш нууц мэдээлэлд хамаарна гэж заасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусган баталж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байгаа боловч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг тогтоож ажиллаагүй байна.

Б.1.2. Аймгийн ИТХ нь журамд заасан төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааны дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум бүрээр тогтоож, шийдвэр гаргаагүй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана”, 13.2-т “Төлбөрийн орлогын хэсэг нь байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын нөөцийн төлбөрийн орлогоос бүрдэнэ” гэж заасан. Мөн Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар хэсэгт төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг зааж өгчээ.

Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа

Хүснэгт: 6

Заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэзээ	Хэнээс	Хаана	Хэрэгжүүлсэн байдал
2.2	Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг хүргүүлэх	IV/01	Аймгийн Засаг дарга	БОАЖЯ	Аймгийн Засаг дарга нь 2023 онд тусгай зориулалтаар агнах угалзын тоо хэмжээний саналыг аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу 2022 оны 391 тоот албан бичгээр БОАЖЯ-д хүргүүлсэн байна.
2.3	Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоох	IV/01	БОАЖЯ	Аймгийн Засаг дарга	2022 оны 391 тоот албан бичгээр хүргүүлсэн 2023 онд тусгай зориулалтаар агнах угалзын тоо хэмжээний саналыг БОАЖЯ хянаж 2022 оны А/208 дугаар тушаалаар тоо хэмжээг баталсан байна.
2.4	Ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум, дүүрэг тус бүрээр тогтоох	VII/01	Аймгийн ИТХ	Сум	2021 2022 онд АИТХ-аас ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг сум тус бүрээр тогтоосон шийдвэрийг гаргаагүй байна.
2.5	Орлогын төлөвлөгөөг БНАТ-1 маягтын дагуу гаргах	VII/25	Сумын Засаг дарга нар	Аймгийн БОАЖГ	Сумдын Засаг дарга нар www.eic.mn Байгаль орчны мэдээллийн санд БНАТ-1 /Сумын төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө/-ыг цахимаар гаргадаг байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт НА

2.6	Орлогын төлөвлөгөөг БНАТ-3 маягтын дагуу боловсруулах	VII/25	Аймгийн БОАЖГ	мэдээллийн санд байршуулах	www.eic.mn системд сумдын төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэн аймгийн төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг БНАТ-3 маягтын дагуу БОАЖГ боловсруулан гаргадаг байна.
2.7	Орлогын төлөвлөгөөг БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулах	VIII/01	Аймгийн БОАЖГ	Аймгийн Засаг даргад	Аймгийн БОАЖГ-аас аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж аймгийн төсвийн саналд нэгтгүүлэхээр Санхүү,Төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга болон БОАЖГ нь төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлэн ажилласан байна. АИТХ нь журмын дагуу байгалийн нөөцийн төрөл, ашиглах дээд хэмжээг сум тус бүрээр тогтоосон шийдвэрийг гаргах, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн “*нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг үндэслэл, журмын дагуу тогтооно*” гэсэн бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь ан агнуурын нөөц ашигласны, ус рашаан ашигласны, газрын нөөцийн төлбөрийн орлогоос бүрдэж байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2021 онд нийт 1,811.5 сая төгрөг үүнээс тооцсон төлбөрийн орлогын хэсэг 351.1 сая төгрөгийг, 2022 онд нийт 8,654.1 сая төгрөгөөс төлбөрийн орлогын хэсэг 1,496.1 сая төгрөгийг, 2023 онд нийт 6,758.3 сая төгрөгөөс төлбөрийн орлогын хэсэг 1,211.5 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөжээ.

Төлбөрийн орлогын хэсгийн тооцоолол

Хүснэгт №7

/сая төгрөг/

Он	БНАТ-ийн орлогын төрөл	Хувь, хэмжээний доод хязгаар	БНАТ-ийн орлогын дүн		БНАТ-ийн орлогын хэсгийн дүн		Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлбөрийн орлогын дүн	Төлбөрийн орлогын хэсгийн дүн
2021	2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50.0%	9.50	216.35	4.75	108.18	206.85	103.43
	3.Газрын нөөцийн төлбөрийн орлого /сум 40%/	15.0%	1,422.03	1,060.03	213.30	159.00	(362.00)	(54.30)
	5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35.0%	380.00	547.58	133.00	191.65	167.58	58.65
Нийт			1,811.53	1,823.96	351.05	458.83	12.43	107.78
2022	2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50.0%	223.08	644.67	111.54	322.33	421.59	210.79
	3.Газрын нөөцийн төлбөрийн орлого	15.0%	7,831.17	7,412.56	1,174.68	1,111.88	(418.60)	(62.79)
	5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35.0%	599.82	700.74	209.94	245.26	100.91	35.32
Нийт			8,654.07	8,757.97	1,496.15	1,679.48	103.90	183.32
2023	2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50.0%	359.60	-	179.80	-	-	-
	3.Газрын нөөцийн төлбөрийн орлого	15.0%	6,039.17	-	905.88	-	-	-
	5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35.0%	359.60	-	125.86	-	-	-
Нийт			6,758.37	-	1,211.54	-		

Орлогын гүйцэтгэлээр байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь 2021 онд нийт 1,824.0 сая төгрөг буюу 12.4 сая төгрөгөөр давж, 2022 онд нийт 8,757.9 сая төгрөг буюу 103.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнээс: ан агнуурын төлбөрийн орлого 2021 онд

206.8 сая, 2022 онд 421.6 сая төгрөгөөр, ус рашааны төлбөрийн орлого 2021 онд 167.6 сая, 2022 онд 100.9 сая төгрөгөөр тус тус давсан байна.


Төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөсөн болон гүйцэтгэлийн дүнгийн зөрүүнээс харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсэг нь 2021 онд 107.8 сая төгрөгөөр, 2022 онд 183.3 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3 дугаар зүйлд “Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төсвийн төсөлд тусгуулахаар жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлнэ” гэж заасан боловч аймгийн БОАЖГ-аас төлбөрийн орлогын давсан хэсгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах саналыг хүргүүлээгүй байна.

Төлбөрийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт

График №1

/сая төгрөг/



Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтэд 2021 онд 351.1 сая төгрөгөөр төлөвлөж 460.5 сая төгрөгийг, 2022 онд 1,496.2 сая төгрөгөөр төлөвлөж 919.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. 2022 оны төлбөрийн орлогын дүн 103.9 сая төгрөгөөр давж биелсэн ба төлбөрийн орлогын хэсгийн гүйцэтгэл 183.3 сая төгрөг байхаар байсан боловч зардлыг 576.5 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Б.1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т “хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох”, Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно”, 29 дүгээр зүйлийн 29.1-т “Тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 25.5-д заасан зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд олгоно”, 29.2.1-т “агнуурын амьтныг эрдэм

шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар агнах, барих тусгай зөвшөөрлийг олгоно” гэж заажээ.

Аймгийн Засаг дарга ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах ан агнуурын нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг агнуурын 6 бүс нутгаас 8 угалзыг тусгай зориулалтаар агнахаар 2022 онд БОАЖГ-аараа дамжуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна. Тус саналыг үндэслэн БОАЖС-ын 2022 оны А/208 тоот тушаалаар аймгийн 4 агнуурын бүс нутагт 10 угалзыг тусгай зориулалтаар агнах хуваарийг баталж, зөвшөөрлийг олгосон байна. Харин 2021 онд тусгай зориулалтаар агнах угалзын тоог БОАЖС-ын 2020 оны А/701 тоот тушаалаар 5 агнуурын бүс нутагт 8 тоо хэмжээгээр баталсан байна

Аймгийн тусгай зориулалтаар агнуулах агнуурын тоо хэмжээ

Хүснэгт №8


Сум	Агнуурын бүс нутгийн нэр	2021	2022	
		БОАЖС-ын 2020 оны А/701 тоот тушаал	БОАЖГ-ын хүргүүлсэн санал	БОАЖС-ын 2020 оны А/208 тоот тушаал
		Агнах угалзын тоо	Агнах угалзын тоо	Агнах угалзын тоо
Өргөн	Аргалын-Уул	2	1	4
Мандах	Таванбаян	1	1	1
Эрдэнэ	Хангинуур	2	2	1
Иххэт	Гурван мандал Эрээн	1	1	0
Хатанбулаг	Хутаг уул	2	2	3
Хатанбулаг	Хатны булаг		1	
	Нийт дүн	8	8	9

БОАЖЯ-ны 2022 оны 06/5143 дугаар зөвшөөрлөөр нэр бүхий 18 аймгийн Улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад нутгаас нийт 20 /хорь/ толгой идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар барих зөвшөөрөл олгосны хүрээнд Алтанширээ сумын Засаг дарга ан агнах зөвшөөрөл бүхий иргэнтэй гэрээ байгуулан 10 идлэг шонхор шувууг барих зөвшөөрлийг олгосон байна.

Усны тухай хуулийн 28.2, 28.3 дахь заалтын дагуу дараах бүрдлийг хангуулан зөвшөөрлийг тус тус олгохоор заасан байна.

Ус ашиглах зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал

График №2



Аймгийн хэмжээнд 2021 онд нийт 284.9 мянган м3/жил усыг ашиглуулахаар 34 дүгнэлтийг, 2022 онд нийт 195.5 мянган м3/жил усыг ашиглуулахаар 30 дүгнэлтийг тус тус олгосон байна.

Ус ашиглуулах 2021 оны нийт 34 дүгнэлтээс 29.9 мянган м3/жил ус ашиглуулах дүгнэлтийг БОАЖГ-аас, 152.9 мянган м3/жил ус ашиглуулах дүгнэлтийг ГӨДГСГ-ын захиргаанаас 2021 онд 5, 2022 онд 6 ус ашиглуулах гэрээг байгуулан 102.1 мянган м3/жил ус ашиглуулах дүгнэлтийг УГГХДТСГ-ын захиргаанаас тус тус гаргасан байна.

Б.1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан тодорхойгүйгээс орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10,12 дугаар зүйлд Усны нөөц ашигласны болон ан амьтны нөөц төлбөр тооцох үзүүлэлтийг тодорхойлсон

Аймгийн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу агнуурын санг удаан хугацааны турш тогтвортой хамгаалах, агнуурын бүс нутгуудад зүй зохистой ашиглалтыг хангахуйцаар агнуурын амьтдын ашиглах дээд хэмжээг тогтоон, Засгийн газрын 155 дугаар тогтоолоор баталсан жишиг үнээр тооцон төлөвлөдөг. Харин ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан тооцон төлөвлөдөг байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг Төсвийн тухай хуульд заасан жилийн төсвийн хязгаарт багтаан боловсруулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө

Хүснэгт №9

/ сая төгрөг/

Дд	Орлогын төрөл	2021			2022		
		СЯ-аас хянан ирүүлсэн хязгаар	Аймгийн Төлөвлөгөө	Зөрүү	СЯ-аас хянан ирүүлсэн хязгаар	Аймгийн Төлөвлөгөө	Зөрүү
1	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	0.00	9.50	9.50	20.00	223.08	203.08
2	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	380.00	380.00	0.00	420.00	599.82	179.82
Нийт		380.00	389.50	9.50	440.00	822.90	382.90

Аймгийн төсөвт 2021 онд ус, рашаан, ан амьтны нөөц ашигласны төлбөрт 389.5 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж 763.9 сая төгрөгийг, 2022 онд 822.9 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж 1,345.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №10

/ сая төгрөг/


Дд	Орлогын төрөл	2021			2022		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	9.50	216.35	206.85	223.08	644.66	421.58
2	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	380.00	547.58	167.58	599.82	700.74	100.92
Нийт		389.50	763.93	374.43	822.90	1345.40	522.50

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 2021 онд 374.4 сая төгрөгөөр буюу 96.1 хувиар, 2022 онд 522.5 сая төгрөгөөр буюу 63.5 хувиар давж биелсэн байна. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2021 онд 206.9 сая төгрөгөөр, 2022

онд 421.6 сая төгрөгөөр давсан байна. Энэ нь БОАЖЯ-аас соёлын зориулалтаар идлэг шонхор барих зөвшөөрлийн дагуу шонхор шувуу барьсантай холбоотой байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл, харьцаа

График №3



2021 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 72 хувийг, 2022 онд 52 хувийг ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого эзэлж байна.

Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, сумын Засаг дарга гэрээ байгуулна” гэж заасан. Аймгийн хэмжээнд БОАЖГ, Галба Өөш Долоодын говийн сав газрын захиргаа болон Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас нийт 2021 онд 34 ус ашиглуулах дүгнэлтийг, 2022 онд 30 ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулжээ. Байгуулсан гэрээ бүрд ус ашиглуулагч нь ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ гэж заасан байна. Аймгийн БОАЖГ-аас жил бүр ус ашиглагч ААНБ-д “Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” албан бичгийг хүргүүлдэг гэх боловч 2021-2022 онд гэрээг дүгнэсэн акт, баримт хангалтгүй, гэрээнд тусгасан үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн байдлыг нотлох боломжгүй байгаа нь аймгийн хэмжээнд ус ашиглагч этгээдийн нэгдсэн тоо мэдээ үнэн зөв, бодитой гарахгүй байх эрсдэлтэй байна. Уг асуудлыг 2022 онд хийгдсэн “Уул уурхайн компаниудын нөхөн сэргээлт, усны нөөцийн ашиглалт” сэдэвт аудитаар зөвлөмжөөр өгсөн байна.

Татварын албанд 2021 онд нийт 34 ус ашиглагчийн 719.9 сая төгрөгийн, 2022 онд нийт 29 ус ашиглагчийн 630.1 сая төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн тайлан ирүүлсэн байна. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого 2021 онд 167.6 сая төгрөгөөр, 2022 онд 100.9 сая төгрөгөөр давж биелсэн боловч 2023 оны байдлаар 459.4 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна” гэж заасан боловч сумдын Засаг дарга нар эрх бүхий албан тушаалтныг томилоогүйгээс төлбөр хураах ажиллагаа цалгардах, татварын орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна.

Б.2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын төлөвлөлтийг менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ бүрээр төлөвлөсөн ч, байгаль орчны чиглэлийн бусад арга хэмжээнд санхүүжилтийг зарцуулсан байна

Б.2.1. Төлбөрийн орлогын хэсгийг хуульд заасан хувь хэмжээг үндэслэн тооцож төлөвлөсөн байна


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сум, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална”, Засгийн газрын 2022 оны “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтын 3.4 “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ журмын 1.2-т заасан орлогын хэмжээнд үндэслэн төсвийн жилийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна” гэж заасан.

Аймгийн ИТХ-аас Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төсвийг батлахдаа менежментийн төлөвлөгөө болон бусад арга хэмжээ тэдгээрт зарцуулах хөрөнгийг нийт дүнгээр баталж, батлагдсан төсвийг аймгийн Засаг дарга үйл ажиллагааны арга хэмжээ, түүнд зарцуулагдах төсвийн задаргааг баталдаг байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15 хувь, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 50 хувь, газрын нөөцийн төлбөрийн орлогоос 15 хувь, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 85 хувь, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос 35 хувийг зарцуулна” заасан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээний доод хязгаар

Зураг №2



Дорноговь аймгийн хэмжээнд ан амьтны нөөц ашигласны төлбөр, газрын нөөцийн төлбөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж баталдаг байна. Байгалийн ургамлын нөөц, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөдөггүй бөгөөд байгалийн нэн ховор, ховор ургамлын тархцын судалгаа байдаг боловч ашиглагч иргэн, аж ахуй нэгж байдаггүй тул байгалийн ургамлын нөөц ашигласнаас орох орлого, тэдгээрийг нөхөн сэргээх зардлыг төлөвлөдөггүй, харин “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт НА

арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журамд заасны дагуу ойжуулах, нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээнд зардлыг төвлөсөн байна.

Дорноговь аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хуульд заасан хувь хэмжээг тооцсон дүн

Хүснэгт №11

/сая төгрөг/

Он	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын		БХНС арга хэмжээнд зарцуулбал зохих хуульд заасан хэмжээ	Аймгийн БХНС арга хэмжээнд төвлөсөн зардал	Зөрүү
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мөнгөн дүн /гүйцэтгэлээр/		
2021	1,811.5	1,824.0	351.1	456.8	105.7
2022	8,654.1	8,758.0	1,496.2	1,513.9	17.7
2023	6,758.4	-	1,211.5	1,302.0	90.5
Дүн	17,224.0	10,582.0	3,058.8	3,272.7	213.9

Хүснэгтээс харахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлээс байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд зарцуулахаар хуульд заасан хувь, хэмжээгээр тооцоход 2021 онд 105.7 сая төгрөг, 2022 онд 17.7 сая төгрөг, 2023 онд 90.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн зардлыг төлөвлөсөн байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан доод хувь хэмжээнээс жил бүр илүү тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн засаг дарга менежментийн төлөвлөгөөний дагуу 2021-2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийг дараах байдлаар баталжээ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв

Хүснэгт №12

/сая төгрөгөөр/

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	2021 он		2022 он		2023 он	
		Арга хэмжээ тоо	Төсөв	Арга хэмжээ тоо	Төсөв	Арга хэмжээ тоо	Төсөв
1	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах	4	44.3	6	18.0	2	20.0
2	Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хангах	1	0.5	-	-	-	-
3	Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах	9	138.0	13	270.5	3	85.0
4	Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын талаар	5	89.5	2	32.0	3	265.0
5	Ойн нөөцийн хамгаалалт, ашиглалтын талаар	6	61.0	6	447.5	4	397.0
6	Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах	4	24.5	1	10.0	-	-
7	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар	2	18.0	6	40.0	4	40.0
8	Салбар дундын зохицуулалт, уялдааг хангаж хамтран ажиллах талаар	1	5.0				
9	Уул уурхай, хяналт шалгалт	0	-	0	-	3	65.0
Дүн		32	380.7	34	818.0	19	872.0
10	Тусгай хамгаалалттай газрын захиргаанд	1	80.0	2	220.0	2	430.0
Нийт дүн		33	460.7	36	1,038.0	21	1,302.0

Дээрх хүснэгтээс харахад Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 2 дугаар тогтоолуудаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журмын төлбөрийн орлогын хэсгийн зарцуулах арга хэмжээнд зааснаас бусад төрлийн арга

хэмжээнд зарцуулахаар 2021 онд 5 арга хэмжээнд 205.8 сая төгрөг, 2022 онд 3 арга хэмжээнд 310.5 сая төгрөг, 2023 онд 3 арга хэмжээнд 190.0 сая төгрөгийг тус тус баталсан байна.

Б.2.2. Төлбөрийн орлогын хэсгийг журамд зааснаас бусад байгаль орчинтой холбоотой арга зориулалт бусаар зарцуулсан байна

Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 2 дугаар тогтоолуудаар баталсан "Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар хэсэгт “Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт”-аар санхүүжүүлж болох арга хэмжээнүүдийг зааж өгсөн байна.

Аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж байгаа зардлыг аудитад хамрагдах онуудаар авч үзвэл дараах байдалтай байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос арга хэмжээнд зарцуулсан төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №13

/сая төгрөг/

№	Утга	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
		2021 он	2022 он	2022 он	2023 он	2023 он	2023 он
1	Усны нөөцийн ашиглалт, хамгаалалттай холбоотой	89.5	86.1	32.0	32.0	265.0	
2	Ойн нөөцийн хамгаалалт, ашиглалт	169.3	169.0	484.3	471.8	397.0	
3	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалах	94.5	94.4	240.0	240.0	420.0	245.0
4	Сургалт зохион байгуулах	-	-	15.9	10.8	20.0	
5	Бусад /зориулалт бус/	107.2	101.2	196.3	165.1	190.0	
Нийт дүн		460.5	450.7	968.5	919.7	1,292.0	245.0

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд олгосон орлогоос Засгийн газрын 2014 оны 43, 2022 оны 2 дугаар тогтоолуудаар баталсан журмын дагуу арга хэмжээнүүдэд 2021 онд 349.5 сая, 2022 онд 754.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.



Агнуурын бүс нутагт 430 боодол өвсийг бэлтгэж, зэрлэг амьтдын тархац газруудад байршуулсан



Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газар нутгийг тэмдэгжүүлэв

Тухайн онуудад хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээний төсвөөс 2021 онд 101.2 сая төгрөг, 2022 онд 165.1 сая төгрөгийг “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-д зааснаас бусад зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.

**Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний
санхүүжилтийн зориулалт бус зарцуулалт**

Хүснэгт №14

/сая төгрөг/

Он	Батлагд- сан зардал	Үүнээс зориулалт бус зардалд баталсан		
		Арга хэмжээний нэр	Зардлын дүн	Жилийн дүн
2021	460.5	БОАЖГ-ын мэргэжилтэн, сумдын байгаль хамгаалагч, хууль, эрх зүйн сургалт, тэмдэглэлт өдрүүд, байцаагч нарыг чадавхжуулах, хувцас, техник хэрэгслээр хангах, дүрэмт хувцас, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, дархлаажуулалтад хамруулах	44.3	101.2
		Хүрээлэн буй орчныг хамгаалах /хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, энгийн болон хур хог хаягдал цэвэрлэх, орчны бохирдолтой холбоотой эко 00, уул уурхайн нөхөн сэргээлт/	41.7	
		Аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулах, "Ай Ти Эм" аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцох, аялал жуулчлалын танилцуулга, гарын авлага бэлтгэх, сурталчлах	15.2	
2022	968.5	Хүрээлэн буй орчныг хамгаалах /хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, энгийн болон хур хог хаягдал цэвэрлэх, орчны бохирдолтой холбоотой эко 00, уул уурхайн нөхөн сэргээлт/	147.3	165.1
		Аялал жуулчлалын эвент арга хэмжээ зохион байгуулах, "Ай Ти Эм" аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцох, аялал жуулчлалын танилцуулга, гарын авлага бэлтгэх, сурталчлах	17.8	
Дүн	1,429.0		266.3	266.3

Аудитаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг зориулалт бусаар зарцуулсан 266.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналтын үр дүнг үнэлээгүй байна.

В.1. Мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, холбогдох төрийн байгууллагын уялдаа холбоог нягтаршуулах шаардлагатай байна.

В.1.1 Мэдээллийн санг бүрэн бүрдүүлээгүй, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т “Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ”, 33.4 “Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна”, 35 дугаар зүйлийн 35.1.17-т “улсын мэдээллийн сан нь “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал”-аас бүрдэнэ”, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.2-т “Төлбөрийн орлогын хэсгийг төлөвлөх, тайлагнахад, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35.1.17-д заасан Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд цахимаар байршуулна” гэж тус тус заасан байна.

Байгаль орчны мэдээллийн сан³-гийн систем нь 23 хэсгээс бүрддэг бөгөөд “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан” хэсэгт мэдээлэл оруулах эрх бүхий хэрэглэгч нь тусгай нууцлалаар нэвтрэхээр системчлэгдсэн байдаг нь иргэд, олон нийт тус мэдээлэлтэй танилцах боломжгүй байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т⁴ заасантай нийцэхгүй байна.

Мэдээ оруулах

Нэвтрэх хэсэг

Мэдээллийн санд мэдээ оруулах эрх бүхий хэрэглэгч нэвтрэнэ.

Нэвтрэх нэр:

Нууц үг:

Нэвтрэх

Болих

Мөн мэдээллийн сангийн системд журмын 2 дугаар зүйлийн 2.5-2.7 заалтад хамаарах мэдээллийг батлагдсан маягтын дагуу байршуулахаар системчилсэн байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан журам⁵ нь тухайн оны 1 дүгээр сард батлагдсан. Гэтэл журамд заасан аймгийн нэгтгэлд хамаарах 8 мэдээллээс 7 мэдээллийг системд огт оруулаагүй, 1 мэдээлэл нь бодит гүйцэтгэлээс зөрүүтэй зэрэг зөрчилтэй байна.

Байгаль орчны мэдээллийн санд мэдээлэл оруулсан байдал

Хүснэгт №15

№	Мэдээллийн сангийн төрөл	Мэдээллийг байршуулсан эсэх (Тийм/Үгүй)	Мэдээллийн зөрүүтэй байдал
А		1	2
1	Аймгийн/ нийслэлийн төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө (БНАТ-3 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй
2	Аймгийн/ нийслэлийн төсөвт төвлөрүүлэх байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний нэгтгэл төлөвлөгөө (БНАТ-4 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй

³ Eic.mn

⁴ Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна

⁵ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам

3	Аймгийн/нийслэлийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогын төлөвлөгөө (БНАТ-5 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй
4	Аймгийн/нийслэлийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний нэгтгэл төлөвлөгөө (БНАТ-6 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй
5	Аймгийн/ нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийн тайлан (БНАТ-9 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй
6	Аймгийн/ нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайлан (БНАТ-10 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй
7	Аймгийн/ нийслэлийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогын гүйцэтгэлийн тайлан (БНАТ-11 маягт)	Үгүй	Мэдээлэл байршуулаагүй
8	Аймгийн/ нийслэлийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогын хэсгийн зарцуулалтын тайлан (БНАТ-12 маягт)	Тийм	684.8 сая төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн

Эх сурвалж: Байгаль орчны мэдээллийн сангийн систем

Системд байршуулах мэдээлэл нь аймгийн ИТХ, Татварын хэлтэс, санхүү төрийн сангийн хэлтэс зэрэг байгууллагаас уялдан гарахаар байна.

Мэдээллийн системийн ач холбогдол, үнэн зөв байдлыг хангахын тулд дээрх байгууллагуудтай уялдаатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

В.1.2. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог нягтаршуулах шаардлагатай байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.18-т “Ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг усны сав газрын захиргаатай хамтран хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга орон нутагт байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг БОАЖГ, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа, Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, БОАЖ-ийн сайдтай байгуулсан гэрээний үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тус аймагт усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын талаар хэрэгжүүлэхээр 2021 онд 89.5 сая төгрөгийн 5 арга хэмжээ, 2022 онд 32.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ батлагдсан байна. Хүн амын ундны эх үүсвэрийн худаг цэвэршүүлэх ажил болон булаг, шанд рашааны эхийг хашиж хамгаалах, тохижуулах арга хэмжээний хүрээнд Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанаас арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ. Мөн газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлын захиалагчийн эрхийг Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанд шилжүүлж, тус сав газар тендерийг зохион байгуулан ажлын гүйцэтгэлийг хүлээн авчээ.

Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.19-т “Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, байгаль орчны мэргэжлийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд Замын-Үүд сумын ойн анги болох “Борхойн баян бүрд” ОНӨААТҮГ нь зөвхөн тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байна. Тус үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг сумын засаг даргад жил бүр тайлагнан ажилладаг байна.

Журмын 3 дугаар зүйлийн 3.20-т “Газрын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын

захиргаа, бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг, малчид, ойн нөхөрлөл, орчны бүсийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах чиглэлээр Дорноговь аймагт 2021 онд 24.5 сая төгрөгийн 4 арга хэмжээ, 2022 онд 10.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 57 дугаар тогтоолоор “Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа” ОНӨААТҮГ-ыг байгуулсан. Энэ нь бүс нутгийн байгалийн унаган төрх, зэрлэг амьтдыг хамгаалах, нөхөн сэргээх, түүх соёлын дурсгалыг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газрын менежментийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах чиг үүрэгтэй ба 2021-2022 онд нийт 15.0 сая төгрөгийн өртөгтэй Хамарын хийд орчимд тэмдэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэжээ.

Аймгийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2021-2022 онд 208,131.4 га газраар нэмэгдсэн боловч төлбөрийн орлогоос хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, төсөв хэвээр байсаар байна. Иймээс эдгээр газар нутгуудад байгалийн нөөц ашигласны орлого, төлбөр, хураамжийн тодорхой хувийг байгаль орчны унаган төрх, төлөв байдлыг хадгалах, хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

В.2. Хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээгээр ирүүлсэн зөвлөмж, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

В.2.1. Хуулийн хэрэгжилтэд холбогдох байгууллагаас хяналт хийгдсэн хэдий ч бодит тоо мэдээлэлд үндэслээгүй байна.

Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6-д “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэл, сум, дүүргийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ”, мөн 4.7-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үнэлгээ хийнэ” гэж заасан.

БОАЖЯ-аас Дорноговь аймгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэхдээ Сангийн яамны гаргасан тоо мэдээг ашигласан байна. Энэ мэдээлэл нь төсвийн гүйцэтгэлийн мэдээнээс зөрүүтэй байна.

БОАЖЯ-аас болон аудитаар илэрсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ (2021-2022 онуудад)
Хүснэгт №16

Он	БОАЖЯ-ны үнэлсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хувь			Аудитаар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хувь			Мэдээллийн зөрүү		
	Хуулийн дагуу зарцуулбал зохих хэмжээ /сая.төг/	СЯ-ны мэдээгээр БНАТ зарцуулсан гүйцэтгэл /сая.төг/	БНАТ-ын хэрэгжилтийн хувь	Хуулийн дагуу зарцуулбал зохих хэмжээ /сая.төг/	БНАТ зарцуулсан гүйцэтгэл /сая.төг/	БНАТ-ын хэрэгжилтийн хувь	Хуулийн дагуу зарцуулбал зохих хэмжээ /сая.төг/	СЯ-ны мэдээгээр БНАТ зарцуулсан гүйцэтгэл /сая.төг/	БНАТ-ын хэрэгжилтийн хувь
А	1	2	3	4	5	6	7=(4-1)	8=(5-2)	9=(6-3)
2021	529.32	89.50	16.91%	456.70	450.60	98.66%	(72.62)	361.10	81.76%
2022	878.83	817.80	93.06%	968.51	919.69	94.96%	89.68	101.89	1.90%

Эх сурвалж: БОАЖЯ-ны “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2022 оны хэрэгжилтийн тайлан

Орлого, зардлын гүйцэтгэлийн зөрүүтэй байдал нь орон нутгийн холбогдох байгууллагаас мэдээг тухай бүр БОАЖЯ-нд хүргүүлээгүй, мэдээллийн системийн уялдаа холбоо, ашиглалт хангалтгүй зэргээс шалтгаалж байна. Мөн хяналт шинжилгээний үр дүнд холбогдох арга хэмжээ авч ажиллах 2021 онд 10, 2022 онд 5 зөвлөмж хүргүүлсэн боловч тухайн зөрчлүүд илэрсэн хэвээр байна.

В.2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 17 дугаар зүйлийн 17.1-т “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан байна.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны 36 дугаар тогтоолоор 6 ажлын хэсэг байгуулан, 14 сумдад 2022 оны 10 дугаар сарын 9-ний өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн дотор нийт 10 асуудлын хүрээнд, үүнээс байгаль орчныг хамгаалах дараах 3 чиглэл⁶-ээр хяналт шалгалтыг хийсэн байна.

Хяналт шалгалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуваарилан санхүүжүүлсэн арга хэмжээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй Тэрбум мод-Үндэсний хөдөлгөөн”, БОАЖЯ-ны санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийг хамруулсан байна. Мөн байгаль орчин хариуцсан мэргэжилтний чиг үүрэгт ажил болон байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг шалгаж холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байна. Гэвч зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж ажилласан нь тодорхойгүй, хэрэгжилтийг тооцоогүй байна.

Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Байгаль орчны тусгай хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасан. Үүний дагуу 2021 онд дараах шийдвэрийг гаргасан байна.

**Аймгийн ИТХ-аас 2021-2023 онд батлагдсан газрыг
улсын болон аймгийн тусгай хамгаалалтад авах
шийдвэрийн мэдээлэл**

Хүснэгт №17

№	Тогтоолын тэргүү	Тогтоолын огноо	Тогтоолын дугаар	Харьяалах газар	Ангилал	Газрын хэмжээ /га/	Хугацаа /жил/	Тайлбар
А	1	2	3	4	5	6	7	
1	Газрын улсын тусгай хамгаалалтад авах санал уламжлах тухай	2021.12.03	05/08	Хатанбулаг, Хөвсгөл сумдын "Шунхатын тал"	Байгалын нөөц газар	91,981.8		Улсын хамгаалалтад авах шийдвэр гараагүй

⁶ 1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн биелэлттэй танилцах

2.Усны тухай хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн хэрэгжилттэй танилцах

3.Газрын тухай хууль тогтоомжийн биелэлт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах, ИТХ-аас батлан гаргасан тогтоол шийдвэрийн биелэлттэй танилцах

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт НА

2	Газрыг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай	05/12	Иххэт сумын "Цэнгэл мааньт"	Байгалын нөөц газар	126,562.0	30	13,321.39 га газар дутуу бүртгэгдсэн
3	Газрыг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай	05/11	Эрдэнэ сумын "Цагаан хайрхан"	Дурсгалт газар	2,555.0	30	Байгалийн нөөц газар гэх ангиллаар бүртгэгдсэн
4	Газрыг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай	05/10	Эрдэнэ сумын "Ар гашуун"	Байгалын нөөц газар	6.2	30	
5	Газрыг аймгийн тусгай хамгаалалтад авах тухай	05/09	Айраг, Алтанширээ, Иххэт сумдын заагт орших "Баастын тал"	Байгалын нөөц газар	79,008.2	30	
Нийт талбайн хэмжээ /га/					208,131.4		

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

Дээрх шийдвэрийг Уул уурхайн компьютерын кадастрын системийн мэдээлэлтэй тулгахад Иххэт сумын "Цэнгэл мааньт"-ын газрын хэмжээг 13,321.39 га газраар дутуу, Эрдэнэ сумын "Цагаан хайрхан"-ны газрын ангиллыг зөрүүлэн бүртгэсэн байна. Энэ нь мэдээллийн сан дахь мэдээлэл нь холбогдох шийдвэртэйгээ нийцэхгүй, мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавиагүй байна.

Мөн байгалийн нөөц газар болон дурсгалт газрын дэглэмийг тусгай хамгаалалтад авах шийдвэрийн хамт баталж байгаа бөгөөд биелэлтэд хяналт шалгалт хийгээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Байгаль орчны талаар мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудын зарим цаглаварт хугацаа хоорондоо нийцэхгүй байна
- Монгол улсын урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагаанаас аймгийн бодлогын баримт бичгүүдэд байгаль орчны талаас хэрэгжүүлэх ажлуудыг тусган хэрэгжүүлэн ажилласан байна.
- Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан боловч БОАЖГ нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан “*менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, үнэлэх, тайлагнах*” үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.
- Аймгийн хэмжээнд нийт 116.9 мянган га ойн сантай боловч ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлын аймгийн ойн менежментийн төлөвлөгөө байхгүй байна.
- БОАЖ-ийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн 81.9-88.9 хувиар үнэлсэн байна.
- Холбогдох байгууллагууд байгалийн нөөцийг тогтоож, ашиглах, төрөл дээд хэмжээг тооцож, шалгуур, үндэслэлийн дагуу төлөвлөдөг хэдий ч, нутгийн өөрөө удирдах байгууллага нь сум тус бүрээр тогтоож, тогтоол шийдвэр гаргаагүй байна.
- Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолд заасны дагуу БОАЖГ-аас төлбөрийн орлогын давсан хэсгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах саналыг хүргүүлээгүй байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна” гэж заасан боловч сумдын Засаг дарга нар эрх бүхий албан тушаалтныг томилоогүй байна.
- БОАЖГ-т байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс 2021-2022 онд нийт 1419.2 сая төгрөг хуваарилснаас 266.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна
- Байгаль орчны мэдээллийн сангийн систем нь 23 хэсгээс бүрддэг бөгөөд “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан” хэсэгт мэдээлэл оруулах эрх бүхий хэрэглэгч нь тусгай нууцлалаар нэвтрэхээр системчлэгдсэн байдаг нь иргэд, олон нийт тус мэдээлэлтэй танилцах боломжгүй байна.
- Мэдээллийн санд аймгийн нэгтгэлд хамаарах байршуулбал зохих 8 мэдээллээс 7 мэдээллийг системд огт оруулаагүй, 1 мэдээлэл нь бодит гүйцэтгэлээс зөрүүтэй байна.
- БОАЖЯ-аас Дорноговь аймгийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэхдээ Сангийн яамны гаргасан тоо мэдээг ашигласан байна. Энэ мэдээлэл нь аудитаар тооцсон орлогын мэдээ нийт 162.3 сая төгрөгөөр, зардлын гүйцэтгэлийн мэдээ 462.99 сая төгрөгөөс зөрүүтэй байна.
- Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2022 онд байгаль орчныг хамгаалах 3 чиглэлээр хяналт шалгалтыг хийсэн байна. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж ажилласан нь тодорхойгүй, хэрэгжилтийг тооцоогүй байна.

Аудитаар нийт 266.3 сая төгрөгийн 11 зөрчил илэрч Үндэсний аудитын газарт 3 санал хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 266.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар холбогдох 3 албан тушаалтанд 7 зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Б.ГАНЗОРИГ ТАНАА:

1. Нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу сум тус бүрээр тогтоон, шийдвэрийг гаргах
2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1, 16.3, 17.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэх

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Ойн тухай хуулийн 17.2.10-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтэд хяналт тавих.
2. Сумдын Засаг дарга нарт байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон, хяналт тавьж төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх чиглэлийг өгч ажиллах

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ОТГОНБАЯР ТАНАА:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг төсвийн төсөлд тусгуулахаар жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргад хүргүүлэн ажиллах
2. Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан “*менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж, үнэлэх, тайлагнах*” үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах
3. Байгаль орчны мэдээллийн сангийн “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан” хэсэгт мэдээллийг үнэн зөв, бүрэн, хугацаанд оруулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

САНАЛ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн ҮАГ-т дараах саналыг хүргүүлж байна.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1-д *"батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх"* гэж заасан цаглаварт хугацааг Төсвийн тухай хуулийн 23.8.4, МУЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам-ын 2.5-д заасан цаглавар хугацаатай нийцүүлэх талаар,
2. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан *"Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар хэсгийн 3.8, 3.9-т заасан цаглаварт хугацааг ижил байх тул цаглаварт хугацааг зөрүүтэй болгохоор журамд өөрчлөлт оруулах талаар,*
3. Байгаль орчны мэдээллийн сангийн орлогын мэдээг Татварын нэгдсэн удирдлагын системээс, зардлын мэдээг Сангийн яамны И-Хуулга системтэй уялдуулан, мэдээллийг нэгтгэдэг байдлаар системчлэх талаар тус тус холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж өгнө үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

1. Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал:


**ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРАЛ**
Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 3009, Факс: (976) 7052 3140,
Цахим шуудан: dornogovi.ith@gmail.com
2023.06.19 № 12/170
танай 2023.06.16 -ны № 1-6/478 -Т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Танай байгууллагаас ирүүлсэн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвийн хүрээнд хийгдсэн нийцлийн аудиттай танилцлаа.

Цаашид тухайн зөвлөмжид тусгагдсан ажлуудыг аймгийн ИТХ-аар хэлэлцэж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах бөгөөд тус тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

**НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА**  **Ц.БАТСУГИР**

 **448230455**

2. Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар:


**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: 7052 2533, Факс: (976) 7052 2530,
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

2023.06.19 № 01/758
танай _____-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Танайхаас ирүүлсэн 2023 оны 1-6/475 тоот
албан бичгийг хүлээн авч танилцлаа.
“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын
тайлан, зөвлөмжид тусгах саналгүй болно.

 О.БАТЖАРГАЛ

44 6230684

3. Дорноговь аймгийн Татварын хэлтэс:


**ДОРНОГОВЬ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС**
Сайншанд сумын ЗДТГ-ын байр, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас/факс: (976) 7052 2471
Цахим шуудан: doernogobi@mta.gov.mn

2023.06.19 № 07/181
таний 2023.06.16-ны № 16/473-т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Төсөлд манай байгууллагаас хүргүүлсэн санал тусгагдсан байх тул нэмж тусгуулах санал байхгүй болно.


ДАРГА Г.ХОСБАЯР

44323037-

4. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар:


**ДОРНОГОВЬ АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2023.06.19 № 319
танай 2023.06.16 -ны № 1-6/474 -т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудит гүйцэтгэсний дагуу тайлан төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд хүргүүлэх санал байхгүй болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ОТГОНБАЯР


9920609, ЗТ0152, 0622030037

442303450

5. Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргаа:



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА
305 тоот, Соёмбо цогцолбор, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас/факс: (976) 7052 3681,
Цахим шуудан: Galba.usgz@gmail.com

2023.06.19 № 148
танай 2023.06.16 -ны № 156/477 -т

┌ ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН ┐
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитыг хийж гүйцэтгэсэн тайлантай танилцлаа.

Сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгах талаар дүгнэлтэд оруулж өгнө үү.

ДАРГА  Б.ЯЛАЛТБАЯР

ТТБ 6954 дт 3312763

• 442230318

ГАЛБА-ӨӨШ ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Ирүүлсэн санал: Сав газрын усны нөөцийн усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгах талаар дүгнэлт оруулах.

Саналд өгөх тайлбар: Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.9-д “*Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.5-д заасан арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-А маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулна*”, 3.10-т “*Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 3.8, 3.9-д заасан нийт арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-6-А маягтын дагуу нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ*” гэж заасны дагуу менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөний саналд тусган шийдвэрлүүлэх хэрэгтэй.

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/20

Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.3, 18.10 дахь заалтууд, 2021 оны А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн 221/А10706617 ДГА-2023/30-8-ШТА-НА тоот албан шаардлагыг баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Татварын хэлтэс, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаанд тус тус хүргүүлсүгэй.
5. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

010010101

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

Т.ГАН-ӨЛЗИЙ
У.ОЮУНТҮЛХҮҮР

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:
ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

О.НАРАНГАРАВ
Д.ДЭМБЭРЭЛСҮРЭН
Б.АЛТАНЗУЛ
М.ДҮҮРЭНЖАРГАЛ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ